

  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 119/01/1270318

Мандалговь

Зорчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хурээнд Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аudit хийлээ.

Аудитаар орон тоо, цалингийн сан батлагдаагүй ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, ажил хавсарсны нэмэгдэлд 2,640,000.00 /Хоёр сая зургаан зуун дөчин мянган/ тегрөгийн цалин бодож олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.5 /төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зардал нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлжс байх/, 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлон захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, 41.2.2 /батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах/, 42.7 /... төсөөт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхуужуулэхийг хориглоно/ заасныг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирагааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсон, хуулиар хулээсэн албан үргээ биелуулээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий дээд газрын шийдвэрийг мөрдөж, орон тооны дагуу ажиллан, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах;

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup> ирүүлэхийг Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Уранцэцэг, Нягтлан бодогч Ө.Уранбилэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР

 Д.ДОЛЖИНСҮРЭН

**БАТАЛГАЛЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Р.МОНХТОГОХ

<sup>1</sup> Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113